



НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025.01.13 № 03 / 223
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах чиглэлийг хүргүүлж байна:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж, мөн зүйлийн 8.2 дахь хэсэгт "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй" гэж тус тус заасан бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд дээрх хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэхээр хуульчилсан.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ." гэж заасан.

Иймд захирамжлалын баримт бичиг, гэрээний төсөл боловсруулах, санал өгөх зэргээр шийдвэр гаргах ажиллагаанд оролцсон албан тушаалтан болон худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан нь дээрх хууль, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/465 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам"-ыг хэрэгжүүлж, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргах, энэ үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх;

2. Төрийн албан хаагч нь захиргааны шийдвэр гаргах аливаа ажиллагаанд дээд шатны албан тушаалтны зөвхөн хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх, удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг

1110200080

үр дагаврыг урьдчилан анхааруулж байх, хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах зэрэг Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлэх, энэ чиглэлээр сургалт мэдээлэл хийх, хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор байгууллагын дарга, албан хаагчдыг Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам"-ын 2.1-т заасны дагуу (АЗ)-ын суурь мэдлэг олгох сургалтад хамруулж, худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнахад мэргэшсэн албан хаагчийг ажиллуулах;

4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж, хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй сахилга, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах;


5.Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 2.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэх;

6.Албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, иргэд олон нийтэд ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэхгүй байхад анхааран тодорхой ажил зохион байгуулах;

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг тодорхойлж, байнга ил тод, нээлттэй байлгахгаар заасан тул хуулийн хэрэгжилтийг ханган мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж байх.

Энэхүү чиглэлийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ үү.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АМГАЛАН

